

ЕБС-ИЙН 10-12-Р АНГИЙН СУРАГЧДАД
АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
(Сургалтын менежерт зориулсан сургалтын модуль)

Д.Мөнхжаргал
/Тольт сургуулийн сургалтын менежер/
munkhjargal@edub.edu.mn

Модулийн зорилго:

Суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны албан ба албан бус сургалтыг сургуулийн түвшинд сургалтын менежер хариуцан ажиллаж, энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэх багш нарт сургалт зохион байгуулах, шаардлагатай эх сурвалж, материалыг боловсруулах, зөвлөгөө өгөх, хяналт дэмжлэг үзүүлэхэд оршино.

Модуль хэрэгжүүлэх зөвлөмж:

Ерөнхий боловсролын сургалтын менежер та ажил мэргэжлийн чиг баримжааг олгох дараах үйл ажиллагаанд дэмжин оролцоно.

- ЕБС нь ажил мэргэжлийн чиг баримжааг олгох үйл ажиллагааг үр дүнтэй явуулснаар сурагчдын сургалтын чанарыг сайжруулах, улмаар ирээдүйн мэргэжлийн сонголтыг зөв хийх алхмын үндэс суурийг тавьдаг. Сургалтын менежер нь ахлах ангийн сурагчдад зориулсан АМЧБО үйл ажиллагаанд зөвлөн туслах, чиглүүлэх, АУБ нарт үр дүнтэй сургалт зохион байгуулж, хяналт тавьж ажилласнаар сурлагын амжилт сайжирдаг. АМЧБО үйл ажиллагааг:
 - өөрийгөө ойлгох,
 - ажлын ертөнцийн талаар ойлголттой болсноор сургалт, ажил мэргэжилтэй холбоотой сонголт хийх,
 - шийдвэр гаргахад нөлөөлөх хүчин зүйлийн талаар ойлгох гэсэн 3 үндсэн үйл ажиллагаатай холбоотой сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлуудыг хийх шаардлагатай байна.
- Аймгийн түвшинд, ахлах ангийн сурагчдад АМЧБО зөвлөл эсвэл баг байгуулж энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж болно. Энэ зөвлөл болон багийг сургуулийн захирал, менежер, нийгмийн ажилтан, багш, эцэг эх, суралцагч болон ажил олгогчийн төлөөллүүдээс бүрдүүлж ажиллах нь илүү үр дүнтэй.
- Хэрэгжилтийн эхний үед хэд хэдэн түвшинд сургалт явуулах хэрэгтэй. Үүнд:
 - сургуулийн
 - зорилтот бүлэгт үйл ажиллагаа явуулдаг багш, ажилтнуудийн
 - аймаг, дүүргийн сургагч багш нарын түвшинд сургалт явуулна.
- Багш бүр ялгаатай байдаг учраас АМЧБО үйл ажиллагааг төлөвлөж ажиллахдаа багшийн бүтээлч чанарыг тухайлбал ангидаа болон хичээлээс гадуурх үйл ажиллагааг илүү санаачлагатай, чанартай зохион байгуулдаг багшаа дэмжин ажиллах нь чухал.
- Сургуулийн удирдлагын нэг болох сургалтын менежер та ажил мэргэжлийн чиг баримжааны талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл дараах онолуудыг судалж үзээрэй. Үүнд:
 - Онцлог шинж чанар болон хүчин зүйлийн онол
 - Хөгжлийн онол
 - Суралцахуй, танин мэдэхүйн онол
 - Социологийн онол
 - Психодинамик онол
 - Хаосын онол

Онолын талаарх мэдээллийг www.myfuture.mn вэб сайтаас дэлгэрэнгүй олж уншаарай.

Агуулга хэрэгжүүлэх сургалтын цагчилсан, төлөвлөгөө:

АМЧБО үйл ажиллагааг явуулах төлөвлөлтийг зөвлөл /баг/ хамтран боловсруулна.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны хүрээг тогтоон тодорхой сэдвийг ахлах ангийн түвшинд хэрэгжүүлэхээр төлөвлөж болно. Үүнд:

Сургуульд суурилсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны загвар:

Сэдэв	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Ажил мэргэжлийн талаар ойлголтыг нэмэгдүүлэх				
Хичээл ажил мэргэжлээ уялдуулж, сурлагын амжилтаа ахиулах				
Ажил мэргэжил болон Их дээд сургуулиудын холбоог уялдуулах				
Хүйсийн ялгаа болон ажил хөдөлмөрийн талаарх итгэл үнэмшлээ таньж мэдэх				

- ✓ Хэрэгжилтийн байдлаас харахад сургуулийн болон ангийн түвшний хөтөлбөрийг боловсруулан ашиглаж байна.


АМЧБО-той холбоотой асуудлуудыг жагсааж, тухайн ангид судлуулахаар төлөвлөнө. Үйл ажиллагааг хичээлийн жилийн хугацаанд хийгдэхээр төлөвлөх бөгөөд албан сургалтыг танхимаар /10-12-р анги тус бүр өөр өөр байж болох/ судлуулах цаг гаргаж өгөх нь үр дүнтэй.

Эзэмших мэдлэг, чадвар:

10-12 дугаар ангийн сурагчид АМЧБО үйл ажиллагаанд хамрагдснаар дараах чадамжийг эзэмшинэ.


Анги	Чадамж
10 дугаар анги	9 дүгээр ангид хийсэн сонголтоо эргэн харах, дахин дүгнэх
	9 дүгээр ангидаа хийсэн төлөвлөгөөгөө эргэж харах, сайжруулах
	Ажил мэргэжлийн талаар илүү бодитой ойлголттой болох
	Ирээдүйгээ төсөөлөх
	Амьдралд гүйцэтгэх үүрэг, үнэт зүйлээ ажил мэргэжилтэй хэрхэн уялдахыг ойлгож ухамсарлах
	11 дүгээр ангид судлах хичээл, хөтөлбөр сонгох
11 дүгээр анги	10 дугаар ангидаа хийсэн төлөвлөгөөгөө эргэж харах, сайжруулах
	Дээд боловсрол, МБС, хөдөлмөрийн зах зээлийн сонголтоо хийх
	Ажил мэргэжлийн сонголтын боломжоо анхааралтай үнэлж дүгнэх
	Дээд боловсрол, МБС-ын талаар түр хугацааны шийдвэр гаргах
Аль их сургуульд элсэх талаар түр хугацааны шийдвэр гаргах	
12 дугаар анги	11 дүгээр ангид хийсэн ажил мэргэжлийн төлөвлөгөөгөө эргэж харах, сайжруулах
	Дээд боловсролын байгууллагад суралцах өргөдөл гаргах
	Ажил хөдөлмөр эрхлэх эсвэл ажилгүй нөхцөл байдалд ороход өөрийгөө бэлтгэх
	МБС-ын байгууллагад суралцах өргөдөл гаргах
Тодорхойгүй нөхцөл байдалд ухаалаг шийдвэр гаргах	

Мэдлэг, чадвар, хандлагын өөрчлөлт гарч буйг дараах жишиг дасгалуудаар тандаж судалж болно.

анги	мэдлэг	чадвар
10	Өөрийнхөө ур чадвар, ажил мэргэжлийн сонирхлоо мэдэх	Ирээдүйгээ төсөөлөх, төлөвлөх
	<p>Дасгал 1. 8-р ангиас эхэлж бичсэн тэмдэглэлээ үргэлжлүүлэн бичих, хэрэв бичдэггүй бол хэрхэн бичиж болох талаар багш зөвлөмжилж бичүүлэх</p>	
	хичээл болон суралцагчдын сонирхож буй ажил мэргэжлийн хоорондын уялдаа холбоог судлах	хичээл болон суралцагчдын сонирхож буй ажил мэргэжлийн хоорондын уялдаа холбоог тодорхойлох
	<p>Дасгал 2. ямар ажил мэргэжил аль хичээлтэй уялдах вэ? гэдэг талаар бусад суралцагчидтай хамтран “тархины шуурга” өрнүүлэх</p> 	
хөдөлмөрийн зах зээл, түүний ажил мэргэжлийн талаарх ойлголт	Ажил мэргэжлийн олон боломжийг судлан, төлөвлөлт хийх	

Дасгал 3.

Ажил мэргэжлийн ялгаатай ба төстэй талыг загварчилсан хүснэгтэд бичих



ажил хөдөлмөр бидний амьдралын үндсэн үүрэгт нөлөөлдгийг таньж мэдэх

мэргэжил сонголтод хүйсийн талаарх итгэл үнэмшил хэрхэн нөлөөлдөг талаар эргэцүүлэх

Дасгал 4.

Ямар ажлуудыг эрэгтэй ба эмэгтэй хүний аль нь хийдэг болохыг загварчилсан хүснэгт эсвэл тусгай бэлтгэсэн материалыг ашиглан чагтлаж бөглөх

АЖИЛ МЭРГЭЖИЛ	ЭРЭГТЭЙ	ЭМЭГТЭЙ	АЛЬ АЛЬ НЬ
Барилгын ажилтан	М	F	В
Онгоцны үйлчлэгч	М	F	В
Нийгмийн ажилтан	М	F	В
Нарийн бичиг	М	F	В
Бага ангийн багш	М	F	В
Үсчин	М	F	В
Загвар өмсөгч	М	F	В
Дэлгүүрийн худалдагч	М	F	В
Малын эмч	М	F	В
Биеийн тамирын багш	М	F	В
Тогооч	М	F	В
Зурагчин	М	F	В
Сувилагч	М	F	В
Агаарын хөлгийн инженер	М	F	В
Галт тэрэгний машинист	М	F	В
Шүдний эмчийн туслах	М	F	В
Уран бүтээлч	М	F	В
Сонины сурвалжлагч	М	F	В
Утасны оператор	М	F	В
Цахилгаанчин	М	F	В
Программист	М	F	В
Эмийн санч	М	F	В
Сонины редактор	М	F	В
Кассчин	М	F	В
Механик инженер	М	F	В
Тагнуулын ажилтан	М	F	В
Сантехникч	М	F	В
Геологич	М	F	В
Банкны теллер	М	F	В
Хоол судлаач	М	F	В
Хамгаалалтын ажилтан	М	F	В

Янз бүрийн ажилд тавигдах хувь хүний, практикийн, хүмүүс хоорондын чадвартай холбоотой шаардлагыг таньж мэдэх

Янз бүрийн ажилд тавигдах хувь хүний, практикийн, хүмүүс хоорондын чадвартай холбоотой шаардлагыг үнэлэж, дүгнэх, өөрийн үнэлгээ хийх

Дасгал

Янз бүрийн мэдээлэл, мэдлэг, ойлголт болон таамаглалаа ашиглан ажлын зарын дагуу тухайн байгууллагын бэлтгэсэн хүснэгтийг дэлгэрэнгүй бөглөхийг хичээгээрэй.

АЛБАН ТУШААЛ	
ЦАЛИН	
АЖИЛ ҮҮРЭГ (Ажлын зар дээр хийж гүйцэтгэх ажил үүргийг тодорхой тайлбарласан байдаг, Хэрвээ тайлбар байхгүй бол холбогдох вэбсайтаас олж болно эсвэл тааж бичиж болно)	
АЖЛЫН НӨХЦӨЛ (жишээ нь ажлын цаг, байршил, ажлын байрны нөхцөл, хөдөө орон нутагт ажиллах, томилолтоор ажиллах тухай)	
ХУВЬ ХҮНД ТАВИХ ШААРДЛАГА (жишээ нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай хувь хүний зан чанар, чадвар гэх мэт)	
БИЕЙН ХҮЧНИЙ ШААРДЛАГА (жишээ нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай биеийн хүчний чадвар гэх мэт)	
ЭНЭ АЖЛЫГ ХИИХЭД ШААРДАГДАХ МЭДЛЭГ, ЧАДВАР (тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, чадвар)	
БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ШААРДЛАГА (ЕБС, ахлах ангид судалсан байх ёстой хичээл, МБС, их, дээд сургууль гэх мэт)	
БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ХУГАЦАА, АГУУЛГА	
СОНИН СЭТГҮҮЛ БОЛОН АЖЛЫН ЗАРЫН САЙТАД ЭНЭ ТӨРЛИЙН ХИЧНЭЭН АЖИЛ БАЙНА ВЭ?	

Миний ур чадвар

Ур чадвартаа дүн шинжилгээ хийх

Дасгал

Ямарч ажил тодорхой чадварыг шаарддаг. Тэгвэл надад дараах чадваруудын аль хэсэг нь төлөвшсөн, аль хэсэг нь хөгжүүлэх шаардлагатай байгааг тэмдэглэж, эдгээрээс хамгийн сайн 5 чадвараар жагсаан бичээрэй.

ХУВЬ ХҮНИЙ ЧАДВАР

Чадвар: Би...	Э	ХШ	Чадвар: Би...	Э	ХШ
Үнэнч шударга			Итгэл даасан		
Бусдаас хараат			Алиа хошин		
Сурах хүсэл эрмэлзэлтэй			Нөхөрсөг, нийтэч		
Өөртөө итгэлтэй			Эмх цэгцтэй		
Зорилготой			Алдаагаа хүлээн зөвшөөрдөг		
Бүтээлч			Шүүмжлэлийг хүлээн авдаг		
Урам зориг дүүрэн, идэвхтэй			Өөрийгөө чөлөөтэй илэрхийлдэг		
Асуудал шийдэгч			Багийн тоглогч		
Нягт нямбай, цаг баримталдаг			Бие даасан		
Практикийн			Эерэг		
Эелдэг			Тайван		
Дасан зохицоходоо сайн			Аналитик		
Амбицтай, есөж хөгжих дуртай			Нүүрэмгий		

Дээрх чадвараас хамгийн сайн "ХУВЬ ХҮНИЙ ЧАДВАР"-аа сонгож, эрэмбэлнэ үү! (1 хамгийн сайн гэх мэт доошоо эрэмбэлнэ):

1.	4.
2.	5.
3.	

өөрийн оюун ухааны хэв шинжийг тодорхойлох

өөрийн оюун ухааны хэв шинжид үндэслэн ажил мэргэжлийн төлөвлөгөө хийх

Дасгал.

Хүснэгт дэх чадваруудыг уншаад, ТИЙМ гэж бодож байвал \checkmark тэмдэглэгээ хийнэ үү.

Хэдэн \checkmark тэмдэглэгээ байгааг тоолно уу.

Хэл ярианы хэв шинж

Өгүүлбэр	Тийм эсэх - \checkmark
Би үгтэй холбоотой тоглоом тоглох дуртай	
Би үгийн сүлжээ, таавар таах дуртай	
Би заримдаа бусад хүний төдийлөн мэддэггүй үг ашигладаг	
Би зарлал, сурталчилгааны үгийг сайн санадаг	
Би ном унших дуртай	
Би математикаас илүү Монгол, Орос, Англи хэлний хичээлдээ сайн	
Би уншсан ном зохиол болон үзсэн киноны талаар хүмүүстэй ярилцах дуртай	
Би эссэ, өдрийн тэмдэглэл, өгүүллэг болон захиа бичих дуртай	
Би ТВ үзэхээс илүүтэй дууны үгийг сонсох дуртай	
Би саяхан нэг зүйлийн талаар юм бичсэн ба хүмүүст их таалагдсан	
БҮГД	

Математик логикийн хэв шинж

Өгүүлбэр	Тийм эсэх - \checkmark
Би шинжлэх ухааны хөгжилд их талархалтай ханддаг	
Би математик болон математик, тоо тооцоолол ашигладаг хичээлд дуртай	
Би шатар гэх мэт спортын төрөлд дуртай	
Би ямар нэг зүйлийн зүй тогтлыг олж, логик дарааллыг илрүүлэх дуртай	
Би ямар нэг зүйлийн учир шалтгааныг нээж илрүүлэх дуртай	
Тооны нэмэх хасах үйлдлийг цээжээр бодох их амархан	
Би бүх зүйлд шинжлэх ухааны үндэслэл, тайлбар байдаг гэдэгт итгэдэг	
Бусад хүн аливаа зүйлд логикгүй хандахад би дургүй	
Би дүн шинжилгээ хийх, ангилах дуртай	
Би ямар нэг асуудлын "хэрэв ... бол яах вэ" гэж бодох дуртай	
БҮГД	

Орон зайн хэв шинж

Өгүүлбэр	Тийм эсэх - \checkmark
Би газрын зургийг их сайн уншдаг	
Би геометрийн хичээлд дуртай	
Миний зүүд ихэвчлэн их тодорхой, тод байдаг	
Би дуртай, дургүй өнгөө их сайн мэддэг	
Би зураг, дүрслэл ихтэй ном, сэтгүүлд илүү дуртай	
Би визуал тааварт их дуртай	
Би сайн мэдэхгүй газар байсан ч замаа сайн олж чаддаг	
Би цаасан дээр эрээчих, зурах дуртай	

Би ямар нэг зүйлийн тайлбарыг зураг дүрслэлд буулган төсөөлөхдөө сайн	
Би утсаараа зураг авах, видео бичлэг хийх дуртай	
БҮГД	

Биеийн хөдөлгөөний, тэнцвэрийн хэв шинж

Өгүүлбэр	Тийм эсэх - √
Би спорт, бүжиг гэх мэт биеэр хийх үйл хөдөлгөөнд дуртай	
Би ямар нэг зүйлийг биеэр хийж сурахыг илүүд үздэг	
Би чөлөөт цагаараа спорт эсвэл бүжиг хийдэг	
Би гар урлал, технологи ашиглах, ямар нэг зүйл барьж бүтээх дуртай	
Би удаан хугацаанд чимээгүй сууж чаддаггүй	
Би ямар нэг зүйлийн талаар сурахдаа гараар хүрч, мэдэрч байж сайн сурдаг	
Миний хөдөлгөөний эвсэл их сайн	
Би ямар нэг зүйлийг тайлбарлах эсвэл өөрийгөө илэрхийлэхдээ гараа ашигладаг	
Би алхаж байхдаа эсвэл ямар нэг зүйл хийж байхдаа илүү сайн санаа олж авдаг	
Би боломжтой л бол гадуур явж чөлөөт цагаа өнгөрөөх дуртай	
БҮГД	

Хөгжмийн хэв шинж

Өгүүлбэр	Тийм эсэх - √
Би хичээл хийж байхдаа эсвэл ямар нэг зүйл хийж байхдаа гараараа эсвэл хөлөөрөө тодорхой хэмнэл товшиж байдаг	
Би амандаа дуу аялахгүй байж чаддаггүй	
Хөгжим миний амьдралын чухал зүйлүүдийн нэг	
Би ямар нэг хөгжим, аялгуу 1-2 удаа сонсоод л тогтоодог	
Хөгжимгүйгээр миний амьдрал бүрэн бүтэн байж чадахгүй	
Би сайн дуулдаг	
Би ажиллаж байхдаа хөгжим сонсох дуртай	
Би их олон дууны ая мэднэ	
Би хөгжим тоглож эсвэл дуу дуулж чадна	
Би хөгжмийн сонгол сайтай, тиймээс хэн нэгэн дуулах юмуу хөгжим тоглоход шууд тааж чадна	
БҮГД	

Хүмүүс хоорондын хэв шинж

Өгүүлбэр	Тийм эсэх - √
Би багийн спортод дуртай	
Би ганцаараа тоглодог тоглоомоос илүүтэй олуулаа тоглодог тоглоом эсвэл хоббитой байхыг илүүд үздэг	
Би өөрийн мэддэг зүйлээ бусадтай хуваалцах дуртай	
Ямар нэг үйл ажиллагаанд би ихэвчлэн удирдан манлайлдаг	
Хүмүүс ихэвчлэн надаас зөвлөгөө авдаг	
Би хүмүүстэй хамт байх дуртай, олуулаа байх нь надад таатай байдаг	
Би нэг биш нэг хэсэг дотны найзтай	
Би сургууль, олон нийтийн ажилд идэвхтэй оролцдог	

Би сургуульдаа хэд хэдэн клуб, дугуйланд явдаг	
Би ямар нэг асуудал тулгарвал өөрөө шийдэх гэж оролдохоос илүүтэй бусадтай ярилцахыг илүүд үздэг	
БҮГД	

Өөр лүүгээ дотогш чиглэсэн хэв шинж

Өгүүлбэр	Тийм эсэх - √
Би амьдралынхаа талаар эргэцүүлэх дуртай	
Би ганцаараа хийдэг хоббитой	
Бусад хүн надтай санал бодлоо төдийлөн хуваалцдаггүй	
Би ганцаараа байх дуртай	
Би өөрийнхөө давуу болон сул талыг мэддэг	
Би бясалгал хийх дуртай	
Би өөрийн гэсэн амьдралын зорилго, зорилттой	
Надад бусад хүн дургүй байдаг ч хийхийг хүсдэг зүйл байдаг	
Би хэн нэгэнтэй хамт ажиллахаас илүүтэй өөрийн гэсэн бизнес эрхлэхийг илүүд үздэг	
Би өөрийнхөө талаар илүү сайн мэдэж болох үйл ажиллагаанд дуртай	
БҮГД	

Байгалийн хэв шинж

Өгүүлбэр	Тийм эсэх - √
Орчны бохирдол намайг их бухимдуулдаг учраас би орчноо бохирдуулахгүй байхыг хичээдэг	
Биологи миний хамгийн дуртай хичээлүүдийн нэг	
Би үүлний өөр өөр хэлбэршилт болон газарзүйн ялгаатай байршлыг сайн мэддэг	
Би амьтанд хайртай	
Би телевизээр байгалийн тухайн хөтөлбөр, нэвтрүүлэг үзэх дуртай	
Би хөдөө аялал зугаалгаар явж байхдаа байгалийн сайхан, амьтан, ургамлыг ажиглах дуртай	
Би гадаа ажиллах дуртай	
Би ургамал, модны нэрийг их сонирхдог	
Би ургамал тарих дуртай	
Би хоол хийж байхдаа бас идэж байхдаа орцыг нь үргэлж сонирхдог. Энэ орцыг хаанаас авсан, хаана тарьж ургуулсан талаар бодох дуртай	
БҮГД	

Дээрх 8 төрлийн чадвар тус бүрд “√” тэмдэглэгээний тоо

Оюун ухааны хэв шинж	√-ийн тоо
Хэл ярианы	
Математик логикийн	
Орон зайн	
Биеийн хөдөлгөөн, тэнцвэрийн	
Хөгжмийн	
Хүмүүс хоорондын	
Өөр лүүгээ дотогш чиглэсэн	
Байгалийн	

	Миний оюун ухааны хамгийн хүчтэй 3 хэв шинж бол:	
	1.	
	2.	
	3.	
	ажил, мэргэжилд тавигдах шаардлагыг судлах	ажил, мэргэжилтэй холбоотой их, дээд сургууль, МБС-ын байгууллагын боломжийн талаар судалж сонголт хийх
	Дасгал Гарын авлага материалуудыг ашиглан ажил мэргэжлийн төлөвлөгөө гарган дараах чиглэлээр судалгаа хийх - Ямар ямар их, дээд сургуулиуд хаана байрладаг, сургалтын хөтөлбөр, ямар хэлбэрээр сурч болох, зардал болон бусад асуудлыг судлах, үнэлгээ хийх	
12	Сургууль төгссөний дараа боловсрол, сургалт, ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн ямар боломж байдгийг судалж мэдэх	Их, дээд сургуульд сурах төлөвлөгөө зохиох
	Дасгал. Өмнөх ангид хийж, судалж, дүгнэсэн зүйлээ эргэн харж, боломжоос өөрт тохирох 5 ажил, мэргэжлээ сонгох, яагаад хамгийн сайн тохирно гэж үзэж байгаагаа тайлбарлан төлөвлөгөө бичих	
	орон нутгийн болон үндэсний хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээллийн эх сурвалжийн талаар олж мэдэх	хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхол, нөөц боломжоо үнэлэх
	Дасгал Улс, нийслэл, аймаг, сум, дүүргийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн талаар хэрхэн мэдээлэл олж авч болох төлөвлөлтийг хийх	
	хөдөлмөр эрхлэх үр чадварынхаа талаар эргэцүүлэх	ажилгүй байх нөхцөлд өөрийгөө удирдаж, зохион байгуулах
	Дасгал Ямар нэгэн ажилд орохын тулд өөрийгөө танилцуулах, танилцуулга бичих, өргөдөл гаргах	

Арга зүй:

Өмнөх хэсэгт сургалтын менежер та ахлах ангийн сурагчдад АМЧБ олгох явцад зайлшгүй эзэмшсэн байх ёстой чадваруудтай танилцсан. Хичээл сонголтыг зөв хийлгэх, ажил мэргэжлээ тохируулан сонгох, өөрийгөө бүрэн дүүрэн танилцуулж сургах дасгал болон үйл ажиллагааг явуулахын тулд багшийн сонгосон арга зүйд дүн шинжилгээ хийж, дараах арга зүйг санал болгож болно.

- хичээл болон суралцагчдын сонирхож буй ажил мэргэжил, боловсрол, сургалтын боломжуудын хоорондын уялдааг таньж мэдэхэд дэмжлэг үзүүлэх
 - тархины шуурга
Ямар ажил мэргэжил, ямар хичээлтэй холбоотойг эсвэл ямар хичээл, ямар мэргэжилтэй холбоотойг бичихдээ сурагчид хосоороо хамтрах, мөн 3-5 сурагчтай багаар ажиллана.
 - Венийн диаграмм
- ажил мэргэжлийн болон сургалтын олон янзын боломжийн талаар эргэцүүлэхэд чиглүүлэх, ажил мэргэжлээ сонгоход нөлөөлөх

- төлөвлөлт хийх судалгааны арга
Аль болох сурагчид өөрсдөө бие даан гүйцэтгэхэд анхаарах. Нэмэлт мэдээлэл, эх сурвалж, ашиглах ном зүйг тодорхой болгох хэрэгтэй. Мөн оюутан сурагч эсвэл төгсөгчид, ажилчин, мэргэжилтэй хүмүүстэй танилцуулж, ажлын байрны аялал хийж болно.
- Өөрийнхөө чадваруудыг таньж мэдэх, бусдад өөрийгөө илэрхийлэхэд дэмжлэг үзүүлэх
 - Жүжигчилсэн тоглолт
Сурагчдын зарим нь ажил олгогч болж тоглон чадвартаа тохируулан өөрийгөө хэрхэн илэрхийлж буйтай танилцана. Энэ тохиолдолд зөв буруу гэсэн дүгнэлтийг хийхгүй.

Мэдлэг, чадвар үнэлэх:

- Ажил мэргэжлийн асуулгаар дамжуулан өөрийн үнэлгээ хийх боломжийг олгох хэрэгтэй.
 - Асуулга

Асуулгыг багш, сурагч, эцэг эхээс авч болно.

- Суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, багшийн ажил мэргэжлийн сэтгэлгээ, итгэл үнэмшил, хандлагыг илрүүлэх ярилцлага хийх
 - Ярилцлага

Ярилцлагыг багш, сурагч, эцэг эхтэй хийж болно.

- 10, 11, 12 дугаар ангийн суралцагчдын эзэмшсэн байх мэдлэг, чадварын бенчмарк боловсруулах
 - Сургуулийн түвшинд боловсруулах
- Чиг хандлагын дүн шинжилгээ хийх
 - Тодорхой шалгуур боловсруулах

Ашиглах ном зүй:

АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулан гаргасан

- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн сурагчийн дасгал ажлын ном/ 2018
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн багшийн гарын авлага/ 2018
- Ажил мэргэжлээ сонгох нь /ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад сонирхол, чадвар болон үнэт зүйлээ тодорхойлох, тохирох ажил мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх сорил/
- Ажил мэргэжлийн чиг баримжаа /Эцэг эх асран хамгаалагчид зориулсан зөвлөмж/
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг төлөвлөх нь /Сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага/ 2018
- Сургуулийн удирдлагын гарын авлага, АХБ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ УЛААНБААТАР 2016
- Багшийн гарын авлага, АХБ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ УЛААНБААТАР 2016

Цахим эх сурвалж:

- www.myfuture.mn
- www.mergejil.mn
- [http //hudulmur-halamj.gov.mn/occ](http://hudulmur-halamj.gov.mn/occ)
- [http //jobclass.ubstat.mn/occ](http://jobclass.ubstat.mn/occ)
- www.onisep.fr
- www.myworldofwork.co.uk
- www.careers.govt.nz
- <https://myfuture.edu.au>
- <https://www.onetonline.org>
- <https://hutulbur.num.edu.mn/>
- <http://ubbirj.ub.gov.mn/>

“Хөгжлөөс хэн ч хоцрох ёсгүй” тогтвортой хөгжлийн уриан дор ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг 2016 оноос эхлэн явуулж байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн боловсролын 4-р зорилт болох “Чанартай боловсрол”-ыг дэмжих үүднээс энэхүү үйл ажиллагааг улам чанаржуулах, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ЕБС-ийн удирдлага, багш, сурагч, эцэг эхчүүдэд зориулсан онлайн орчин бүрдүүлж, цахим сургалтын модуль боловсруулсан.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагаа нь сурагч өөрийгөө таньж мэдэх, үнэт зүйлээ хамгаалах, ажил мэргэжлээ зөв сонгох, хөдөлмөрийг үнэлж сурахад нь дэмжлэг үзүүлэх, ерөнхий боловсролын тогтолцоонд үр дүнтэйгээр нэвтрүүлэх, багш, сурагч, эцэг эх, сургуулийн удирдлагын мэдлэг, чадвар, хандлагыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Иймээс нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, жендерийн мэдрэмжтэйгээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Түүнчлэн мэргэжил сонголтод жендерийн талаарх хэвшмэл хандлагаас сэргийлэн хичээл, үйл ажиллагааг мэдрэмжтэй удирдан зохион байгуулж охид, хөвгүүдийн боломж ижил тэнцүү байдаг талаас нь ойлгуулна.

Түгээмэл биш ажил мэргэжлийн талаар ярилцахдаа илүү мэдрэмжтэй байж охид, хөвгүүдийн тэгш оролцоог хангаж ажиллах, суралцагчдад аль болох олон төрлийн ажил мэргэжлийн талаар ойлгож мэдэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

